

“ҮНЭ ТОГТВОРЖУУЛАХ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ” СЭДЭВТ НИЙЦЛИЙН АУДИТ

Нийцлийн аудитын газраас 2015 оны 09 дүгээр сарын 30-ны өдөр ирүүлсэн 2/1215 тоот албан бичгийн дагуу Төв аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулахаар “Эрчимжсэн мал аж ахуй”-н хөтөлбөрт хамрагдсан 7 аж ахуй нэгжийн зээлийн зарцуулалтанд шалгалт хийлээ. Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, асуудлын шинжилгээ, арга зүйн дэд түвшний 3-дугаар бүлгийн 3.2, 3.4 д заасан асуудлын хүрээнд тайланг бичлээ.

Аудитад хамрагдсан 7 аж ахуй нэгжээс дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон зээлийг Хишигтэн нүүдэлчин ХХК, Зургаан хошуу ХХК-ууд нь зориулалтын дагуу зарцуулж үйл ажиллагаагаа явуулж байна. Хайрхан трейд ХХК нь үйл ажиллагаа нь эхлэж, Алтанмандал ХХК нь зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэх нь анхан шатны баримтаар нотлогдохгүй байна. Данзамд хайрхан ХХК, Мөнхийн Монгол ургац ХХК, Ноёнтуул ХХК-ууд нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн хугацаанд ҮХААЯам, Мал аж ахуйн бодлого хэрэгжилтийг зохицуулалтын газар, Монгол банкнаас тус аж ахуй нэгжүүдэд шалгалт огт хийгдээгүй байна. Энэ нь гэрээний эрх үүргийн 2.1-д “хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийн хүрээнд ерөнхий нөхцөл, хэрэгжүүлэх арга, чиг үүргийг тодорхойлж хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллана” гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

ХИШИГТЭН НҮҮДЭЛЧИН ХХК:

Нүүдэлчин групп нь Уул уурхайн салбарт “Мондулаан трейд” ХХК, “Уул уурхайн үндэсний олборлогч” ХХК, “Нүүдэлчин айрон ресорс” ХХК, барилга угсралт, барилгын материал үйлдвэрлэлийн салбарт “Арга барил” ХХК, хүнсний үйлдвэрлэлийн салбарт “Эрдэнэт гурил” ХХК, хөдөө аж ахуйн салбарын голлох чиглэл болох механикжсан газар тариалан, эрчимжсэн мал аж ахуйн чиглэлд “Хишигтэн нүүдэлчин” ХХК-ийг үүсгэн байгуулж зургаан охин, нэг хараат компанитайгаар ажиллаж байна.

МУЗГазраас хэрэгжүүлж буй “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” төслийн хүрээнд Үйлдвэр Хөдөө аж ахуйн яамтай Мондулаан трейд ХХК нь 2013 оны 08 дугаар сарын 07-ны өдөр Мах сүүний үхрийн эрчимжүүлсэн аж ахуйг Төв аймгийн Архуст сумын нутаг дэвсгэрт хийж гүйцэтгэхээр ТГ/13-ДХХ-01/03 дугаар бүхий 15 тоот гэрээ байгуулсан боловч тус гэрээ нь тамга тэмдэг, гарын үсэггүй байна.

Зээлдэгч Мондулаан ХХК нь хамтран үүрэг гүйцэтгэгчээр Нүүдэлчин групп, Хишигтэн нүүдэлчин ХХК, Нүүдэлчин ургийн овогт Ш.Лхамсүрэн нарыг оролцуулахаар ХААН банктэй зээлийн гэрээ байгуулж 2013 оны 11-р сарын 25-ны өдөр 1800.0 сая төгрөгийн зээл авсан байна. Мондулаан ХХК нь Хишигтэн нүүдэлчин ХХК-д хоорондын тооцоогоор санхүүжилтийг шилжүүлсэн байна.

Хишигтэн нүүдэлчин ХХК нь 2011.07.25-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлж газар тариалан, таван хошуу мал, фермийн аж ахуй, сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэх

зөвшөөрөлтэй байгуулагдсан байна. 2013 оноос эхлэн Төв аймгийн Архуст сумын 1-р багийн нутагт газар тариалан, фермийн үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.

Нүүдэлчин групп нь 2013 онд Франц улсын COOPEX MONTBELIARDE LLC -с цэвэр цусны МОНТБЕЛИАРД үүлдрийн 155 ш хээлтэй үнээ, 5 ширхэг бух худалдан авахаар гэрээ хийсэн байна. Мондулаан ХХК нь үхрийн төлбөрийг COOPEX MONTBELIARDE LLC шилжүүлж тухай бүр нь Хишигтэн нүүдэлчин ХХК руу хоорондыг тооцоо үүсгэн бүртгэсэн байна. 2013 онд үхрийн үнэнд нийт 1575.8 сая төгрөгийг шилжүүлсэн. Үнээний фермийн барилгын үнийн урдчилгаанд 220.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Хишигтэн нүүдэлчин ХХК-ний 2013 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг үзэхэд санхүүгийн байдлын тайлангийн эргэлтийн бус хөрөнгийн хэсэгт биологийн хөрөнгө нь 1959.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 1577.6 сая төгрөг нь үхрийн үнэ байна. Байгууллагын хөрөнгийн бүртгэлд 150 толгой гунж 1503.1 сая төгрөг, 5 толгой бух 74.5 сая төгрөгийн бүртгэлтэй байна.

Аудитын явцад Төв аймгийн Аудитын газрын аудиторуд 2015 оны 10-р сарын 13-ны өдөр Архуст суманд очиж сумын удирдлагууд болон мэргэжилтэнгүүдтэй уулзан, Хишигтэн нүүдэлчин компанийн үйл ажиллагаатай танилцсан.

- Төв аймгийн Архуст сумын Засаг даргын 2011 оны 10-р сарын 31-ны өдрийн 300 тоот захирамжаар Мон Дулаантрейд ХХК-ны Архуст сумын Ноён шанд 1-р багийн эзэмшиж байсан 4166 га талбайгаас 2933 га газрыг Хишигтэн нүүдэлчин ХХК-д үр тариа тарих зориулалтаар эзэмшүүлэхээр шилжүүлсэн байна. Аж ахуй нэгж байгууллагын газар эзэмших гэрчилгээг 2013 оны 05-р сарын 14 ны өдөр Сумын газрын даамал бичиж олгосон байна.
- Төв аймгийн Архуст сумын нутагт Хишигтэн нүүдэлчин ХХК-д мал тооллогын А дансаар 2013 оны жилийн эцэст 155 толгой үхэр, 311 толгой адуу тоологдсон байна. 2014 оны жилийн эцэст тугал-120 толгой , 2 наст 106 толгой, 3 наст 304 толгой, нийт 557 толгой үхэр, 434 толгой адуу тоологдсон байна. Үхэр нь өмнөх оноос 402 толгойгоор нэмэгдсэн байна.
- 2014 онд МОНТБЕЛИАРД үүлдрийн 150 үнээ нэмж худалдан авсан байна.
- Хишигтэн нүүдэлчин ХХК нь 200 өсвөр үхрийн байр, 400 үнээний үхрийн байр, саалийн үнээний бүрэн механикжсан тоног төхөөрөмжтэй байр, ажиллагсдын орон сууц, шинээр хөдөө аж ахуйн зориулалттай компайн, 4 төрлийн тоног төхөөрөмжүүдийг бэлтгэсэн байна.
- АПУ компанитай Сүү бэлтгэн нийлүүлэх тухай 2014 оны 06-р сарын 04-ны өдрийн 03/14055 тоот гэрээ байгуулсан байна. Уг гэрээнд 1л сүүг 1000 төгрөгөөр, өдөрт 1800 кг сүү нийлүүлэхээр гэрээ хийж АПУ компанид сүүгээ бэлтгэн нийлүүлдэг байна.
- Хишигтэн нүүдэлчин ХХК нь Төв аймгийн Архуст сумын 1-р багийн нутагт эрчимжсэн мал аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулж 2013 онд 152.9 сая төгрөгийн борлуулалт, 2014 онд 703.5 сая төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна.
- 2933 га талбайг эргэлтэнд оруулан өөрийн хэрэгцээт малын тэжээлийг бэлтгэж байна.

- Үйл ажиллагаа нь тогтмолжсон тус фермид 24 ажилтан ажиллаж, ажлын байраар хангагдсан байна. Үүнээс Төв аймгийн Архуст сумын 1-р багаас 3 хүн ажиллаж байна.



Үхрийн байр, ажилчдын байр

ЗУРГААН ХОШУУ ХХК:

МУЗГазраас хэрэгжүүлж буй “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд гахайн “фермерийн өргөтгөлийн эрчимт цогцолбор” төсөл хэрэгжүүлэхээр 3000.0 сая төгрөгийн төслийг Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яаманд 2013 оны 5 сард хүргүүлсэн байна.

Зургаан хошуу ХХК нь “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” төслийн хүрээнд Төв аймгийн Баянцогт сумын нутаг дэвсгэрт махны чиглэлийн гахайн фермийн аж ахуйг өргөжүүлэхээр Үйлдвэр Хөдөө аж ахуйн яамтай 2013 оны 08 дугаар сарын 18-ны өдрийн ТГ/13/-ДХХ-01/02 дугаар бүхий 02 тоот гэрээ байгуулан 2013 оны

11 дүгээр сарын 25-нд ХААН банкны 5721016097 тоот дансаар 1000.0 сая төгрөгийн зээлийг авсан байна.

Зургаан хошуу ХХК нь 2014 оны 04 дүгээр сарын 02-нд 398.3 сая төгрөгийн зээлийг буцаан төлж, 300.0 сая төгрөгийг гахайн будаанд зарцуулж, 301.7 сая төгрөгийг гахайн фермерийн өргөтгөлийн ажилд зарцуулсан байна.

Аудитаар 2015 оны 10-р сарын 13-ний өдөр газар дээр нь очиж шалгахад:

Фермерийн барилгад өргөтгөл хийж нядалгаанд орохын өмнөх сойлгын байр, гахайн төрх байранд 30 ширхэг төрх ор шинээр нэмж суурилуулсан, ажилчдын орон сууцны хуучин барилгын дээвэр, цонх, дотор заслын ажлууд цэвэр бохир усны шугмын асуудлыг иж бүрэн гүйцэтгэсэн, уурын зуухны барилгын байрыг дээвэр, цонх, фермерийн дулааны шугам сүлжээг шинчилсэн, 6 автомашины граш шинээр барьсан, тэжээлийн үйлдвэрийн нэг шугамыг шинэчилэн засварлаж будаа хүлээн авах талбайг төрөлжүүлсэн, мах сэрвээх хадгалах зориулалттай хөргүүрийг шинээр барьж ашиглалтанд оруулсан байна.



Нядалгааны өмнөх сойлгын байр, мах сэрвээх хөргүүр, гахайн байр

- 2014 оны жилийн эцсийн тооллогоор хээлтэгч 350, хээлтүүлэгч 20, бусад 3520, нийт 3890 тоо толгой гахай Улаанбаатар хотын Сонгино хайрхан дүүргийн 20-р хороонд тоологдсон малын А данс ирүүлсэн.
- 2013, 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд зээл, хөрөнгө, орлогыг бүрэн тусгасан гэсэн Пантер мидланд аудит ХХК-аар баталгаажуулсан байна.
- Дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 11 дүгээр сарын 25-нд 1000.0 сая төгрөгийн зээл авсанаас хойш 41.4 сая төгрөгийн хүү нэмэгдэж, графикайн дагуу зээл хүүгийн хамт 725.0 сая төгрөг төлж, 2015 оны 9 сарын 20-ны байдлаар 316.5 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй, хугацаа

хэтэрсэн зээл байхгүй графикийн дагуу төлөлтийг бүрэн хийсэн байна./зээлийн хуулгыг хавсаргав/

- 2007 онд Зургаан хошуу ХХК-д эрх шилжүүлэх гэрээгээр фермерийн зориулалтын 4.5 га газар олгосон боловч 2.2 га-г үлдээж 2.3 га газрыг орон нутаг буцаасан байна. Мөн үр тарианы зориулалтын 2800 га газартай байсныг 1000 га-г үлдээж 1800 га газрыг орон нутагт буцаасан байна. Хөтөлбөрийн хугацаанд тариалалт огт хийгээгүй байна.
- Хөтөлбөрийн хугацаанд сум болон аймагт үл хөдлөх хөрөнгийн татварт 3.8 сая төгрөг, усны төлбөрт 0.8 сая төгрөг, газрын төлбөрт 2.3 сая төгрөг, хог хаядлын хураамж 0.4 сая төгрөг төлсөн байна. / Баянцогт сумын татварын улсын байцаагчаар татвар төлөлтийн судалгааг гаргуулан авч хавсаргав/.
- Үнэ тогтворжуулах төслийн хүрээнд “меркури” захад борлуулалтын лангуу ажиллуулж борлуулалт хийн гахайн гулууз махны 1кг тутмын үнийг 6.2-7.8 мянган төгрөгөөр борлуулсан нь нийт 956.8 сая төгрөгний борлуулалтын 30-иад хувийг эзлэж байна.

Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр шинээр ажлын байр нэмэгдсэн гэх боловч тогтвортой ажлын байр нэмэгдсэн нь /анхан шатны баримт болон НД-тайлан/ баримтаар нотлогдохгүй байна.

ХАЙРХАН ТРЕЙД ХХК:

МУЗГазраас хэрэгжүүлж буй “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд Хайрхан трейд ХХК нь “Мах-сүүний чиглэлийн фермийн аж ахуй”-н ажлыг Төв аймгийн Аргалант сумны нутаг дэвсгэрт хэрэгжүүлэхээр Капитал банкнаас 4000.0 сая төгрөгийн зээлийг жилийн 3.89 хувийн хүүтэйгээр 1080 хоног буюу 3 жилийн хугацаатай зээл авсан байна.

Капитал банк зээлийг олгохдоо барьцаа хөрөнгө нь хүрэхгүйгээс шууд 4000.0 сая төгрөгийг шилжүүлэлгүй барьцаа хөрөнгийн хэмжээгээр цувуулан 2013 оны 12 сард 2026.0 сая төгрөг, 2014 оны 1 сард 1100.0 сая төгрөг, 3-р сард 374.0 сая төгрөг, 2015 оны 1-р сард 500.0 сая төгрөг нийт 4000.0 сая төгрөгийн зээлийг олгосон байна.

Үнэ тогтворжуулах төслийг хэрэгжүүлэхээр авсан 4000.0 сая төгрөгийн зээлийг Хайрхан трейд компани нь мал, тэжээлд 1522.4 сая төгрөг, материал тоног төхөөрөмжийн зардалд 791.8 сая төгрөг, тээвэр шатахуунд 180.4 сая төгрөг, ажлын хөлсөнд 1315.8 сая төгрөг, зээлийн эргэн төлөлт хүүнд 189.6 сая төгрөг зарцуулсан гэж зарцуулалтыг гаргаж өгсөн боловч анхан шатны баримт хангалтгүй байна.

Хайрхан трейд ХХК-ны санхүүгийн тайлангаас харахад 2014 онд биологийн хөрөнгө 986.6 сая төгрөгөөр нэмэгдсэн боловч хэдэн толгой ямар мал хаана бүртгэлтэй нь тодорхойгүй байна. Аргалант сумын 2014 оны малын тооллогын бүртгэлийн А дансны бүртгэлийг авч үзэхэд 200 үхэр тоологдсон байна. 2014 оны санхүүгийн анхан

шатны баримтыг шалгахад 342 толгой үхэр авахад 189.6 сая төгрөг зарцуулсан баримт байна. Санхүүгийн тайланд тусгасан 986.6 сая төгрөгөөс анхан шатны баримтаар нотлогдох 189.6 төгрөгийн үхрийн үнийг хасвал 796.9 сая төгрөгөөр үхэр авсан нотлогдохгүй байна.

Аудитаар Хайрхан трейд ХХК-ны үхрийн мах, сүүний чиглэлийн фермийн үйл ажиллагаатай 2015 оны 10-р сарын 13-нд очиж танилцлаа. Тус компанид Аргалант сумаас мах, сүүний чиглэлийн фермерийн аж ахуй эрхлэхээр бэлчээр, фермийн зориулалтаар 8 га, мал сүргийн тэжээлийн хангамжийг шийдэх зорилгоор 90 га тариалангийн талбайг эзэмших эрхийг 2014 онд авсан байна. Фермерийн объектын зориулалтаар авсан газар дээр 100 үнээний байр, 100 үхрийн махны чиглэлээр тэжээх тэжээлийн байрны барилга 583.4 сая төгрөгөөр баригдсан байна. Мөн гүний худаг гаргасан, тэжээлийн агуулах, ажилчдын 2 зуны байр тус тус баригдсан байна.

4000.0 сая төгрөгний зээлээс 2629.2 сая төгрөг зориулалтын дагуу зарцуулагдаж анхан шатны баримтаар нотлогдсон. 1370.7 сая төгрөгийн зардлын анхан шатны баримт дутуу учир юунд зарцуулсан нь нотлогдохгүй байна.

2015 оны эхний хагас жилийн тайлангаар 3836.1 сая төгрөгөөр зээлийн үлдэгдлийг тусгасан байна. Зээлийн эргэн төлөлтийн батлагдсан хувиараар 2014 оны 12 сараас үндсэн зээлийг төлж эхлэх ёстой. 2015 оны 1-р сард эргэн төлөх хуваарийн дагуу 2014 оны 12 сард 20.0 сая төгрөг, 2015 оны 1-р сард 20.0 сая төгрөг нийт 40.0 сая төгрөгийн үндсэн зээлийн төлөлтийг хийснээс өөр төлөлт хийгдээгүй байна.



100 үнээний байр, тэжээлийн байр, тэжээл хадгалах агуулах



Ажилчдын байр, гүний худаг

АЛТАН МАНДАЛ ХХК:

МУЗГазраас хэрэгжүүлж буй "Гол нэрийн бараа, бүтээгдхүүний үнийг тогтворжуулах" төслийн хүрээнд мах, мах-сүүний чиглэлийн үхрийн аж ахуйг хөгжүүлэх төслийг Төв аймгийн Батсүмбэр суманд хэрэгжүүлэхээр Алтан мандал ХХК нь Үйлдвэр Хөдөө Аж Ахуйн Яамтай 2013 оны 12-р сарын 09-ний өдөр ТГ/13/-ДХХ-01/03 дугаар бүхий 42 тоот гэрээ байгуулан, 2014 оны 5-р сард Капитал банкнаас 250.0 сая төгрөгийн зээл авсан байна. Зээлийн эргэн төлөлтийн хуваариар 2015 оны 09-р сарын 15-ний байдлаар үндсэн зээлийн төлбөрт 62.5 сая төгрөг, хүүгийн төлбөрт 12.8 сая төгрөг нийт 75.3 сая төгрөг төлөхөөс 23.7 сая төгрөгийг төлж, 51.6 сая төгрөгийн дутуу төлөлттэй байна.

Алтанмандал ХХК нь төслийн зээлийн эх үүсвэрээр үнээний байр барихад 45.8 сая төгрөг, өсвөр үхрийн хашаа саравч байр 2 ш –ийг барихад 53.8 сая төгрөг, Үхэр худалдаж авахад 100.0 сая төгрөг, ажилчдын сууц барихад 15.0 сая төгрөг, Тэжээлийн агуулах /контейнер -20 тн/ авахад 5.0 сая төгрөг, Fuso автомашиныг 30.0 сая төгрөгөөр худалдан авсан гэсэн жагсаалтыг гаргаж ирүүлсэн. Зээлийн зарцуулалт, худалдан авалт нь анхан шатны ямар ч баримтгүй, нотлогдохгүй байна. Мөн аж ахуйн нэгжийн 2014 оны жилийн эцсийн болон 2015 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлан балансад зээл, хөрөнгө, орлогыг тайлагнаагүй байна.

Аудитаар 2015 оны 10-р сарын 13-ний өдөр газар дээр нь очиж шалгахад:

1. Төв аймгийн Батсүмбэр суманд үнээний фермерийг барьсан гэсэн боловч үхрийн фермер шинээр баригдаагүй.
2. Үхэр худалдан авсан гэрээ, нотлох баримт байхгүй, үзүүлээгүй. Хашаанд 21 тугал бэлнээр тооллогдсон, үхэр бэлчээрт гарсан тул тооллогдоогүй
3. 2014 оны жилийн эцсийн мал тооллогоор Алтанмандал ХХК-ний нэр дээр мал тооллогдсон бүртгэл байхгүй талаар Батсүмбэр сумын 1 дүгээр багийн Засаг даргын албан тоот ирүүлсэн.

4. Үхрийн хашаа, саравч, ажиллагсдын байр, тэжээлийн агуулахыг өсвөр үхрийн отрын нутаг Сүхбаатар аймгийн Мөнххаан суманд баригдсан тул ҮАГазарт Сүхбаатар аймгийн Аудитын газарт уламжлан газар дээр нь үзүүлэх саналыг тавьсан.
5. Батсүмбэр суманд ажиллах явцад сумын Засаг даргатай ярилцахад сум орон нутгаас тодорхойлолт аваагүй болохоор Алтанмандал ХХК –ийг төсөл хэрэгжүүлж байгааг мэдээгүй, сум орон нутагт ажил хийгдээгүй тухай тодорхойлж албан тоот ирүүлсэн.
6. Алтанмандал ХХК нь хөтөлбөр хэрэгжүүлснээр малчин -2, саальчин-2, жолооч -1, гэрээт малын эмч -1 гэсэн ажлын байр нэмэгдүүлсэн гэх ба ажиллагсдын Нийгмийн даатгалын шимтгэл төлөгдөөгүй, цалин олгосон цалингийн цэс байхгүй тул баримтаар нотлогдохгүй байна.

ДАНЗАМД ХАЙРХАН ХХК:

Данзамд хайрхан ХХК-ийн авсан 3.5 тэрбум төгрөгийн зарцуулалт болон төслийн үйл ажиллагааны талаар тус компанийн захирал М.Дамдинхүүгээс 99025085 дугаартай утсанд холбогдож тодорүүлга авлаа. Үүнд:

- Данзамд хайрхан ХХК нь төсөл хэрэгжүүлэхээр 1.5 тэрбум төгрөг авсан ба Налайх дүүрэгт гахайны аж ахуй эрхэлж байгаа
- Үлдсэн 2.0 тэрбум төгрөгийг Хөхтана ХХК авсан ба захирал Энх-Амараас энэ талаар лавлаж асууна уу утасны дугаар нь 99113151 гэсний дагуу холбогдоход “манай компани Төв аймгийн Заамар суманд үхрийн аж ахуй эрхэлж байгаа, би гадаад яваад 5 хоногийн дараа ирнэ” гэсэн хариулт өгөв.

Заамар сумын татварын байцаагч болон Засаг даргаас тодруулахад “ийм нэртэй компани манай орон нутагт ямарч үйл ажиллагаа явуулдаггүй” энэ байдлыг тодорхойлж албан тоот ирүүлсэн.

Дээрх Данзамд хайрхан ХХК-нь Төв аймагт үйл ажиллагаа явуулдаггүй мөн Хөхтана ХХК нь Заамар суманд үйл ажиллагаа явуулаагүй байна. Эдгээр компанийн талаар мэдээллийг Нийцлийн аудитын газрын аудитор Дорждуламд танилцуулсан.

МӨНХИЙН МОНГОЛ УРГАЦ ХХК:

Мөнхийн Монгол ургац ХХК-ийн авсан 2.5 тэрбум төгрөгийн зарцуулалт болон төслийн үйл ажиллагааны талаар тус компанийн захирал Х.Бат-Өлзийгөөс 95952349 дугаартай утсанд холбогдож тодорүүлга авлаа. Үүнд:

- Манайх үйл ажиллагаа явуулаагүй, шүүхээр явж байгаа, Монгол банк, Төрийн банкаар шалгуулж байгаа холбогдох материалыг биеэр авч очих боломжгүй уулзаж чадахгүй гэсэн хариу өгсөн.

Борнуур сумын Засаг дарга болон Санхүүгийн тасгийн дарга С.Энхжаргал нараас тодруулахад “Мөнхийн Монгол ургац ХХК нь гахайн фермерийн үйл ажиллагааг орон нутагт эрхэлдэггүй” энэ байдлыг тодорхойлж албан тоот ирүүлсэн.

НОЁН ТУУЛ ХХК:

Ноён туул ХХК-ийн авсан 1.8 тэрбум төгрөгийн зарцуулалт болон төслийн үйл ажиллагааны талаар тус компанийн захирал С.Пүрэв-Очоос 99110304, 98008558 дугаартай утсанд холбогдож тодруулга авах гэж удаа дараалан олон удаа залгасан боловч 99110304 дугаар нь дуудлагаа авахгүй, 98008558 дугаар нь ашиглалтанд байхгүй байсан.

Сэргэлэн сумын Засаг дарга Т.Гансүх болон Санхүүгийн тасгийн дарга Н.Даваасүрэн нараас тодруулсан.

Ноён туул ХХК нь мах, сүүний чиглэлийн фермерийн үйл ажиллагааг орон нутагт эрхэлдэггүй, энэ байдлыг тодорхойлж албан тоот ирүүлсэн.